



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

БАРИЛГЫН АЖЛЫН МАТЕРИАЛЫН ҮНЭ, ТЭЭВРИЙН ЗАЙН
БОДИТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: СБА-2025/31-17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой холбоотой мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баруун-Урт 2025 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх
аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn
Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл 5
БҮЛЭГ А. ТӨСӨВ БАТЛАХДАА ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЗУРАГ ТӨСӨВ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ХАМТ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА..... 6

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөсөн боловч 532.6 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг зөрүүтэй хуваарилсан байна..... 6

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэр бүрдүүлэлтийг Сангийн яам төлөвлөж байна. ... 6

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримтлан, хуваарилж олгосон байна. 6

1.1.3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох 8,637.2 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс 532.6 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна..... 6

1.1.4. Аймаг, сумын ОНХС-д хуульд заасан эх үүсвэрийг судалж, орон нутгийн хөгжлийн санд 14,523.1 сая төгрөг нэмж төлөвлөжээ..... 7

1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдийн оролцоотойгоор нээлттэй хэлэлцэж, хөдөлмөр эрхлэлт болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой уялдуулан төлөвлөх, мөн техникийн тодорхойлолт болон зураг төсвийг төсөв батлагдахаас өмнө боловсруулах шаардлагатай байна..... 7

1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт болон холбогдох мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр нийтэд мэдээлж, иргэдийн оролцоог ханган нээлттэй хэлэлцэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна. 7

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хөдөлмөр эрхлэлт, ЖДҮ-ийг дэмжих бодлоготой уялдуулах шаардлагатай байна. 9

1.2.3. Барилгын ажлын зураг төсөл болон тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг төсөв батлагдахаас өмнө бэлтгэж хэвшүүлээгүй, энэ нь Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангахгүй байгаагийн улмаас зөрчил давтан гарсаар байна..... 10

1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 63,039.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 373 төсөл арга хэмжээг журамд заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. 11

БҮЛЭГ Б. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН 373 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНЭЭС 30 ХУВЬ НЬ ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА. 12

2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй зөрчил гарсаар байна..... 12

2.1.1. Магадлалаар баталгаажаагүй зураг төслөөр тендер зарлах нь тухайн тендер сонгон шалгаруулалтыг амжилтгүй болгоход голлон нөлөөлж байна. 12

2.1.2. Хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосоор байна. 13

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 373 төсөл, арга хэмжээнээс 30 хувь нь огт хэрэгжээгүй байна.	14
2.2.1. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байхад төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглалтад оруулсан нь төлөвлөсөн зорилт, үр дүнд хүрэх боломжийг хязгаарлаж, зөрчил одоог хүртэл арилаагүй байна. 14	
2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 373 төсөл, арга хэмжээнээс 112 буюу 30 хувь нь огт хэрэгжээгүй байна.	15
2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.	16
2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.	16
2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна.	16
БҮЛЭГ В. САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭР ОЛГОЖ, МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН, ҮНЭН ЗӨВ БАЙРШУУЛАН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА. 17	
3.1. Захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, санхүүжилтийг зөвхөн бодит гүйцэтгэлийн дагуу олгох шаардлагатай байна.	17
3.1.1. Барилгын ажлын санхүүжилт, материалын чанар, тухайн үеийн зах зээлийн үнийг бодитоор хянахын тулд хяналт шалгалтыг системтэй хэрэгжүүлж, албан хаагчдыг төсөвчний сургалтад хамруулах шаардлагатай байна.	17
3.1.2. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага хийгээгүй ажлыг хийснээр гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлэхгүй байна.	17
3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмж дутуу хэрэгжилттэй байна.	18
3.2. Сумдын байршуулж буй мэдээллийг удирдлагын мэдээллийн систем болон шилэн дансанд бүрэн гүйцэд оруулаагүйгээс төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын мэдээлэл бүрэн ил тод бус болж, хяналт, аудитын үр дүн буурах, шийдвэр гаргах үйл явц удааширах эрсдэл үүсэж байна.	19
3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан байна.	19
3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээний 99.5 хувийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.	19
3.2.3. Удирдлагын мэдээллийн системд олгосон санхүүжилтийн мэдээллийг бүрэн гүйцэд мэдээлсэн боловч зарим төсөл арга хэмжээний төсөвт өртөг, гэрээний дүнг зөрүүтэй мэдээлсэн байна.	20
3.2.4. Аймгийн ЗДТГ-ын ОНХС-ын мэргэжилтэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэлд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.	20
Холбогдох байгууллагын санал:	21
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	23
ДҮГНЭЛТ: 23	
ЗӨВЛӨМЖ: 24	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
БОНХОБТХ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УИХ	Улсын Их хурал

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсөл арга хэмжээний эх үүсвэр	6
Хүснэгт 2	Орлогын шилжүүлэг	6
Хүснэгт 3	Төсөл арга хэмжээний батлагдсан төсөвт өртөг	10
Хүснэгт 4	Төсөл арга хэмжээний хэрэгжилт	14
Хүснэгт 5	Зөвлөмжийн хэрэгжилт	17
Хүснэгт 6	Төсөл арга хэмжээний данс бүртгэл	18

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
Аудит үндэслэл, эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А107, "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад ОНХС-ийн 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөл, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг дарга, харьяа байгууллагууд, аймгийн Засаг даргын тамгын газар, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагчийн алба болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа авах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2025 оны 08 сарын 25-ны өдрөөс 09 дүгээр сарын 26-ний өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. ТӨСӨВ БАТЛАХДАА ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЗУРАГ ТӨСӨВ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ХАМТ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөсөн боловч 532.6 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг зөрүүтэй хуваарилсан байна.

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэр бүрдүүлэлтийг Сангийн яам төлөвлөж байна.

1.1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Сангийн яамны эрх, үүргийн хүрээнд хэрэгждэг бөгөөд аймаг, орон нутгийн засаг захиргааны чиг үүрэгт хамааралгүй болохыг тодотгон мэдэгдэж байна. Иймд энэ асуудал нь орон нутгийн хяналт, шалгалтын хүрээнд хамаараагүй болно.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримтлан, хуваарилж олгосон байна.

1.1.2.1. ОНХНС-аас Сүхбаатар аймгийн орон нутгийн хөгжлийн санд 17,515.4 сая төгрөгийг хууль, журмын дагуу олгосон байна. Аймагт 2024 онд олгосон шилжүүлгийг эх үүсвэрээр ангилж, хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Төсөл арга хэмжээний эх үүсвэр,

/сая.төг/

№	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Төсвийн тухай хуулийн 60.2.1 /олгосон орлогын шилжүүлэг/	14,726.9
2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	275.1
3	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	417.4
4	ОУ-ын байгууллагын төслөөс олгож буй урамшуулал	2,096.0
Нийт дүн		17,515.4

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ын санхүүгийн тайлан

1.1.3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох 8,637.2 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс 532.6 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.3.1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д 2024 онд олговол зохих 8,637.2 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Орлогын шилжүүлэг

/сая.төг/

№	Сумын нэр	Орлогын шилжүүлэг	№	Сумын нэр	Орлогын шилжүүлэг
1	Асгат	440.1	8	Сүхбаатар сум	1,986.9
2	Баруун-Урт	1,039.8	9	Түвшинширээ	383.0
3	Баяндэлгэр	639.5	10	Түмэнцогт	267.0
4	Дарьганга	309.4	11	Уулбаян	354.4

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө					
5	Мөнххаан	700.0	12	Халзан	216.3
6	Наран	195.0	13	Эрдэнэцагаан	1,717.5
7	Онгон	388.3			
Дүн					8,637.2

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ын санхүүгийн тайлан

1.1.3.1. Тодруулбал Баруун-Урт, Мөнххаан, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдад 30.4-188.2 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Түвшинширээ, Халзан сумдад 52.9-161.8 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг илүү тус тус шилжүүлж, нийт 532.6 сая төгрөгийг зөрүүлэн шилжүүлж, хуваарийн дагуу олгоогүй байна. Тодруулбал 2024 оны 12 дугаар сарын санхүүжилтийг олгохдоо санамсаргүй алдаа гарснаас орлогын шилжүүлгийг зөрүүтэй олгожээ.

1.1.4. Аймаг, сумын ОНХС-д хуульд заасан эх үүсвэрийг судалж, орон нутгийн хөгжлийн санд 14,523.1 сая төгрөг нэмж төлөвлөжээ.

1.1.4.1. Аймгийн хэмжээнд Орон нутгийн хөгжлийн санд (ОНХС) орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг судалж, 14,523.1 сая төгрөг хуваарилахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 2,416.9 сая төгрөг хуваарилагджээ. Энэ нь төлөвлөгөөний 16.6%-ийг л хангасан гэсэн үг юм. Орлого дутуу хуваарилагдсан шалтгаануудыг задлан харвал:

1.1.4.2. Аймгийн ОНХС-д Төсвийн тухай хуулийн 60.2.4-т заасны дагуу татварын болон татварын бус орлого (газрын дуудлага худалдааны орлого, хамтран ажиллах гэрээний төлбөр) 9,490.0 сая төгрөгийг хуваарилахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 410.0 сая төгрөг төвлөрч, энэ нь төлөвлөгөөний 4.3 хувь бөгөөд татварын болон татварын бус орлогын эх үүсвэрээс хүлээгдэж байсан орлого хангалтгүй төвлөрсөн.

1.1.4.3. Сумдын ОНХС-ийн орлого нь малын тоо толгойн албан татвараас бүрддэг. Гэвч 2023–2024 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс шалтгаалан зарим сумын ИТХ татварыг тэглэсэн, малын тоо цөөрснөөр татварын орлого хугацаандаа бүрэн төвлөрөөгүй. Үүний улмаас орлого 3,065.1 сая төгрөгөөр тасарч, ОНХС-ийн эх үүсвэр дутагдалтай болсон байна.

1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдийн оролцоотойгоор нээлттэй хэлэлцэж, хөдөлмөр эрхлэлт болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой уялдуулан төлөвлөх, мөн техникийн тодорхойлолт болон зураг төсвийг төсөв батлагдахаас өмнө боловсруулах шаардлагатай байна.

1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт болон холбогдох мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр нийтэд мэдээлж, иргэдийн оролцоог ханган нээлттэй хэлэлцэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

1.2.1.1. Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн

Хурал орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний жагсаалтыг иргэдийн санал, оролцоогүйгээр баталжээ. Мөн аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн хүрээнд иргэд олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байна.

1.2.1.2. Иргэдийн саналыг тусгаагүй, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүйгээс төсөл, арга хэмжээний төлөвлөлт орон нутгийн бодит хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чадаагүй. Энэ нь төлөвлөлтийн ил тод байдал, иргэдийн оролцоог хангах тухай хууль, журмын шаардлагыг хангаагүйтэй холбоотой юм.

1.2.1.3. Иргэдийн оролцоогүйгээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, иргэдийн хүлээлттэй нийцэхгүй байх, улмаар санхүүжилтийн үр ашиг буурах, иргэдийн итгэл алдагдах, хөгжлийн тэнцвэргүй байдал бий болох эрсдэлтэй.

1.2.1.4. Тус аудитаар иргэдээс авсан санал, асуулгын нэгтгэлээс авч үзэхэд санал, асуулгад оролцсон иргэдийн дийлэнх буюу 50-иас дээш хувь нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх болон хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний талаарх мэдээлэл маш хангалтгүй, мэдээллээр хангах шаардлагатай байгаа талаар санал өгсөн байна.

1.2.1.5. Иймд аудитын баг иргэдэд мэдээллийг иж бүрэн хүргэх, тэдгээрийн санал, оролцоог ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үе шатанд нэмэгдүүлэх боломж, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. Иргэд олон нийтийн цахим системээр дамжуулан хоорондоо ярилцлага, хэлэлцүүлэг хийх боломжийг бүрдүүлэх нь иргэдийн мэдээлэл авах, санал өгөх, оролцоог хангах үр нөлөөтэй гэж үзсэн.

1.2.1.6. Иймд ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 5.2.2-т заасан “Бүлгийн ярилцлага”¹, 7.5-д заасан “Нээлттэй хэлэлцүүлэг”² зэргийг олон нийтийн цахим системээр дамжуулан зохион байгуулах нь зүйтэй байна. Цахим системээр зохион байгуулах “Бүлгийн ярилцлага”, “Нээлттэй хэлэлцүүлэг”-т иргэдийг хамруулснаар ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн санал хангалттай хэмжээгээр тусч, төсвийн төлөвлөлт ил тод байх шаардлага хангагдаж, иргэдийн оролцоо нэмэгдэхээр байна.

1.2.1.7. Сүхбаатар аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 373 төсөл, арга хэмжээг 36,650.8 сая төгрөгөөр 2024 онд санхүүжүүлэхээр батлагдсан байна. Жилийн эцсийн байдлаар аймагт 19,700 өрх бүртгэгдсэн бөгөөд ОНХС-ийн төлөвлөлтөд

¹ Орон нутгийн иргэд өөрсдөд тулгамдаж буй асуудлаар нийтийн ашиг сонирхлыг илэрхийлж сайн дурын үндсэн дээр нэгдсэн бүлгийн зохион байгуулалт

² Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

иргэн, өрх бүрийн саналын оролцоо чухал ач холбогдолтой. Батлагдсан төсөвт үндэслэн нэг өрхөд ногдох саналын эрхийн үнэ цэнийг тооцоход дунджаар 1.8 сая төгрөгийн үнэ бүхий саналын эрхтэй байна.

1.2.1.8. Өөрөөр хэлбэл, төлөвлөлтөд санал өгч оролцоогүй иргэдтэй харьцуулахад санал өгсөн иргэдийн оролцоо, саналын үнэ цэнэ харьцангуй өндөр байна. Иймд нэг өрхөд ногдох санал, оролцооны үнэ цэнийг төгрөгөөр илэрхийлсэн инфографик болон богино хэмжээний видео бичлэгийг олон нийтийн цахим сүлжээгээр түгээснээр иргэдийн оролцооны идэвхийг нэмэгдүүлэх боломжтой. Мөн нээлттэй хэлэлцүүлэг, бүлгийн ярилцлагыг танхим болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулж, иргэд, өрхийн төлөөллийн оролцоог өргөжүүлэх шаардлагатай. Нээлттэй хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг нутгийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хаяг болон олон дагагчтай пэйж хуудсаар түгээх нь оролцоог нэмэгдүүлэхэд үр дүнтэй байна.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хөдөлмөр эрхлэлт, ЖДҮ-ийг дэмжих бодлоготой уялдуулах шаардлагатай байна.

1.2.2.1. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.2.7-т “Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт”, 4.2.8-т “Ажлын байр бий болгох”-д чиглэсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн иргэдийн хамтарч хоршоо байгуулах, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах хэрэгцээтэй уялдуулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүний хүрээнд хоршоодын үйлдвэрлэл эрхлэхэд шаардагдах барилга байгууламжийн асуудлыг бага өртөгтэй, түрээсийн төлбөр багатай, цахилгаан, халаалт, холбоо зэрэг иж бүрэн дэд бүтцэд холбогдсон барилга байгууламжийг ОНХС-ийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулснаар шийдвэрлэх боломжтой сайн туршлага байна.

1.2.2.2. Мөн тухайн хоршооны гишүүдийн нарийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хэрэгцээг хангахын тулд үе шаттай шалгаруулалтаар шаардлага хангасан гишүүдийг хоршооны үйл ажиллагааны чиглэлтэй уялдсан техникийн нарийн мэргэжлийн (гагнуур, оёдол, хүнсний үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, газар тариалан, хөдөө аж ахуй гэх мэт) сургалтад хамруулах боломжтой. Ийм сургалтын төлбөрийг ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.2.7-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх боломжтой байна.

1.2.2.3. Нэгтгэн дүгнэхэд, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх ажлын байрны барилга байгууламжийг хямд түрээсээр шийдвэрлэх боломжийг ОНХС-ийн журмын 4.2.8-д, эргэлтийн хөрөнгө болон тоног төхөөрөмжийн санхүүжилтийг Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр, харин хоршооны гишүүдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлбөрийг ОНХС-ийн журмын 4.2.7-д тус тус зохицуулсан. Өөрөөр хэлбэл, ажлын байр бий болгох арга хэмжээг дээрх чиглэлүүдтэй уялдуулан

цогцоор нь авч үзэж хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд иргэдийг хоршиж, хамтран ажиллах үйл ажиллагааг эдгээр сангийн хөрөнгөөр дэмжих шаардлагатай байна.

1.2.2.4. Түүнчлэн орон нутгийн хоршоод хоорондын хамтын ажиллагааг дэмжих үүднээс бусад хоршоодын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авдаг буюу хамтран ажилладаг хоршоодын ажлын байрны түрээсийн өртгийг хямдруулах, гишүүдийг нь ОНХС-ийн хөрөнгөөр сургалтад хамруулах, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлд хамруулах, хоршоо эрхлэгч нарыг чадавхжуулах сургалтаар бүх талаар дэмжих замаар цогц бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1.2.3. Барилгын ажлын зураг төсөл болон тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг төсөв батлагдахаас өмнө бэлтгэж хэвшүүлээгүй, энэ нь Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангахгүй байгаагийн улмаас зөрчил давтан гарсаар байна.

1.2.3.1. Аймаг, сумын 2024 оны орон нутгийн төсөв нь 2023 оны 12 дугаар сард батлагдсан ч, батлагдах хугацаанаас өмнө зураг төсөл нь хийгдээгүй 7,719.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 төсөл, арга хэмжээ байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөл батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгосон төсөл, арга хэмжээг тусгах” шаардлагыг зөрчиж, төсвийн үр ашгийг бууруулах, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд эрсдэл үүсгэж байна.

1.3.3.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөснөөс үүдэн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй буюу тухайн ондоо хэрэгжүүлээгүй 7,261.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл арга хэмжээ байна. Энэ нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг хүртэх боломжийг 1 жилийн хугацаанд алдахад хүргэж байна.

1.3.3.3. Орон нутгийн төсөв батлагдсаны дараа буюу тендер зарлахын өмнө тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулж, баталдаг нийтлэг буруу жишиг тогтсоны улмаас төсөвлөлт бодит бус, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд эрсдэл үүсч байна. Төсөв батлагдахаас өмнө техникийн тодорхойлолт бэлтгэх нь 1) төсөвлөлтийн шаардлагыг хангах, 2) мэргэжлийн байгууллагаар тоног төхөөрөмжийн зах зээлийн үнийн судалгаа хийлгэснээр төсөвт өртгийг бодитой тодорхойлох боломжийг олгож, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлдэг.

1.3.3.4. Иймд цаашид барилгын ажлын зураг төсөлтэй адил, тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг төсөвт тусгахаас өмнө бэлтгэж батлуулж, холбогдох хууль, журмын шаардлагыг бүрэн хангах шаардлагатай байна.

1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 63,039.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 373 төсөл арга хэмжээг журамд заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.4.1. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 63,039.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 373 төсөл арга хэмжээнүүдийн хувьд ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийн хүрээнд байна.

1.2.4.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээнүүдийг орон нутгийн хөгжлийн сангийн журамд заасан чиг үүргээр ангилж, дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Төсөл арга хэмжээний батлагдсан төсөвт өртөг

(сая.төгрөг)

№	Журамд заасан чиг үүргийн ангилал /Аймаг, сум/	Төсөл арга хэмжээний	
		Тоо	Батлагдсан төсөвт өртөг
1	Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	70	25,526.8
2	Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	98	19,077.6
3	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологи	91	9,671.4
4	Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах	20	4,544.2
5	Ажлын байр бий болгох	2	623.0
6	Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах	11	1,390.4
7	Малын татварын орлогоор - Бэлчээрийн менежментийг сайжруулах	8	628.9
8	Малын татварын орлогоор - Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.	11	232.5
9	Малын татварын орлогоор - Тэжээлийн нөөц бүрдүүлэх;	26	956.6
10	Малын татварын орлогоор - Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;	14	178.9
11	Малын татварын орлогоор - Малын чанарыг сайжруулах;	13	141.0
12	Малын татварын орлогоор - Байгаль орчныг хамгаалах;	6	41.6
13	Малын татварын орлогоор - Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;	3	26.2
Нийт дүн		373	63,039.4

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол

1.2.4.3. Сүхбаатар аймаг болон сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан 63,039.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 373 төсөл, арга хэмжээний 70.8 хувь буюу 44,631.9 сая төгрөг нь дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ, орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн төслүүдэд төлөвлөгдсөн байна.

1.2.4.4. Дэд бүтцийн хөгжил, орчны тохижилт, байгаль орчны хамгаалалт нь орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл бөгөөд иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд онцгой ач холбогдолтой тул ОНХС-ийн төсвийн дийлэнх хувийг эдгээр чиглэлд хуваарилсан байна.

БҮЛЭГ Б. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН 373 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНЭЭС 30 ХУВЬ НЬ ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй зөрчил гарсаар байна.

2.1.1. Магадлалаар баталгаажаагүй зураг төслөөр тендер зарлах нь тухайн тендер сонгон шалгаруулалтыг амжилтгүй болгоход голлон нөлөөлж байна.

2.1.1.1. Сүхбаатар аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 24,551.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 төсөл арга хэмжээнд тендер зарласан байна. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 42, харьцуулалтын аргаар 50, гэрээ шууд байгуулах аргаар 1 төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулсан байна. Эдгээр зарласан тендерээс оролцогч компаниуд шаардлага хангаагүй болон нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй зэрэг шалтгаанаар 2,658.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 тендер амжилтгүй болсон байна.

2.1.1.2. Тендерийн санал ирүүлээгүй буюу нэг оролцогчгүй 17 төсөл арга хэмжээнд тендерийн баримт бичиг боловсруулалт, tender.gov.mn сайтад хавсаргасан бичиг баримтуудад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах шалтгаануудтай байна. Үүнд 1-рт зураг төслийг төсөв батлагдсанаас хойш буюу 2024 онд хийлгэж хугацаа алдсан, 2-рт магадлалын дүгнэлт гаргуулсан боловч зөвхөн ажлын зургийг хавсаргаж, хяналтын төсвийг байршуулаагүй, 3-рт ажлын зураг төсөл нь магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй зураг төсөв хавсаргаж тендер зарласан, 4-рт ажлын тендерийг барааны тендерээр зарласан, 5-рт магадлалын дүгнэлтийн хүчинтэй хугацаа буюу 2 жилийн хугацаа дууссан зураг төслөөр тендер зарласан байна. Үүний улмаас тендерт оролцох боломж хязгаарлагдан, төсөл, арга хэмжээний хэрэгжилт саатаж, төсвийн үр ашгийг бууруулах эрсдэл үүсэж байна.

2.1.1.3. Дээрх шалтгаануудын улмаас тухайн төсөл арга хэмжээнд оролцох сонирхолтой компаниудад тодорхойгүй байдал үүссэн тул тендерт оролцоогүй байж болзошгүй байна. Эдгээр 17 төсөл арга хэмжээнүүдээс тухайлбал 3 төсөл арга хэмжээний тендерийг 4-6 удаа зарласан боловч нэг ч компани оролцоогүй байна. Өөрөөр хэлбэл төсөл арга хэмжээний мэдээлэл тодорхой бус, дутуу байх нь тендерийг компаниуд сонирхохгүй байхад нөлөөлж байна.

2.1.1.4. Тендерийн баримт бичигт хяналтын төсвийг иж бүрэн хавсаргаж, тухайлбал “*барилгын ажлын үе шатаар гаргасан өртгийн товчоо*” болон “*барилга угсралтын зардлыг ажлын нэрээр гаргасан ажлын нэгтгэл*”-ийг багтаах

шаардлагатай бөгөөд, мөн эдгээр нэгж өртгийн төсвийг ирүүлэх зааврыг тендерт оролцогчдод тусгаж, үнэлгээний үе шатанд оролцогчийн ирүүлсэн нэгж өртгийн төсвийг хяналтын төсвийн нэгж өртөгтэй харьцуулан үндэслэлгүй зөрүүтэй санал ирүүлсэн эсэхийг шалгаж, шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох нь төсвийн хяналт, тендерийн ил тод байдлыг хангаж, төсөл, арга хэмжээний зардлыг үр ашигтай, бодитой төлөвлөх боломжийг нэмэгдүүлэх юм.

2.1.1.5. Түвшинширээ сумын хувьд “Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон зудын нөхцөл байдлын үеийн зардал /өвс, тэжээл худалдан авах/” төсөл арга хэмжээнд 104.0 сая төгрөг баталж, 91.6 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, “Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх” төсөл арга хэмжээнд 72.5 сая төгрөг баталж, 31.7 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. Мөн Түмэнцогт сумын хувьд “Малын тэжээлийн нөөц бүрдүүлэлт өвс” төсөл, арга хэмжээнд 40.0 сая төгрөг баталж, 35.0 сая төгрөгийн шууд худалдан авалт хийжээ. Эдгээр сумд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй зөрчил гаргасан байна.

2.1.1.6. Түмэнцогт сумын хувьд 1, 2-р багийн тохижилт, 1,2-р багийн гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж болон 3, 4-р багийн гэрэлтүүлгийн засварын ажлуудыг нэгтгэн багцалж тендер зарлах боломжтой байхад тус бүрийг задалж, дөрвөн төсөл, арга хэмжээнд хуваан баталж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зөрчлийг санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн.

2.1.1.7. Түвшинширээ, Түмэнцогт сумдын төсөл, арга хэмжээнд батлагдсан төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй шууд худалдан авалт хийсэн нь төсвийн үр ашгийг бууруулах, хөрөнгө зарцуулалтын хяналт алдагдах эрсдэл үүсгэж байна

2.1.1.8. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэртэй дөрвөн тендерт оролцогч компаниуд Сангийн яаманд гомдол гаргасныг хянан үзэхэд, гурван төсөл, арга хэмжээ болох “Аймгийн төвийн багуудыг камержуулалтын нэгдсэн системд холбох /Баруун-Урт сум/”, “Ногоон байгууламж нэмэгдүүлэх хүрээнд модны нүх ухдаг трактор худалдан авах /Баруун-Урт/”, “Ерөнхий гэрээгээр худалдан авах сургуулийн тоног төхөөрөмж, эд хогшил /Баруун-Урт сум 3-р сургууль/” тендерт анх шалгарсан компани шаардлага хангаагүй гэж үзэж, дараагийн компаниудтай гэрээ байгуулсан бол, “Усны машин худалдан авах /Наран сум/” төсөл, арга хэмжээний хувьд үнэлгээний хороо дахин хуралдаж, анх шалгарсан компанитай гэрээ байгуулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.

2.1.2. Хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосоор байна.

2.1.2.1. Гэрээ байгуулсан төсөл арга хэмжээнүүдийг авч үзэхэд 32,257.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 253 төсөл арга хэмжээг тайлант онд хэрэгжсэн

байна. Үүнээс 14,509.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 196 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 16,255.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 51 төсөл арга хэмжээний хэрэгжилт дутуу байна. Дутуу хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтэд 5,836.2 сая төгрөг олгосон байна.

2.1.2.2. Эрдэнэцагаан сумын “Засмал зам тавих” төсөл, арга хэмжээний хувьд түр замын ажил нь ажлын зураг, нарийвчилсан төсөвт өртөггүй, замын үндсэн трасс дээгүүр хийсэн гэж 86.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн хайрга, дайргыг 2 км орчим газраас тээвэрлэсэн боловч 5 км-ээс тээвэрлэснээр гүйцэтгэл гаргаж, газар шорооны ажил дутуу хийгдсэн байхад гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилт олгосон.

2.1.2.3. Наран сумын “Шинэ уурын зуух барих” төсөл, арга хэмжээний хувьд 1.0 мвт-ын зуух 2-ыг суурилуулах байтал 0.8 мвт-ын зуух 1-ийг суурилуулж, 300.0 сая төгрөгийн санхүүжилт олгож 237.6 сая төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон.

2.1.2.4. Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэн, Уртын голын цэцэрлэгт хүрээлэнгийн хамгаалах зурвасын хашаа барих, Талын наран зохиолч яруу найрагчдын цэцэрлэгт хүрээлэн, Аймгийн төвийн гэрэлтүүлэг шинэчлэх зэрэг төсөл арга хэмжээнүүдийн хувьд материалын чанар, хэмжээ болон бусад үзүүлэлтүүд нь төсөвт туссан үнэ болон зах зээлийн үнэтэй харьцуулахад багагүй хэмжээний зөрүүтэй байгаа нь аудитын явцад ажиглагдсан бөгөөд гүйцэтгэгч компаниудаас тайлбар, тодруулга авах ажиллагаа хийгдэж байна. Эдгээр асуудлыг санхүүгийн завсрын аудитаар эцэслэн шийдвэрлэх ажиллагаа хийгдэх юм.

2.1.2.5 Баруун-Урт сумын “Багийн нутаг дэвсгэрийг камержуулах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн ажлын тоо хэмжээ зөрүүтэй, зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй, ажлын төсөвтэй байхад барааны тендерээр зарласан нь аудитын явцад ажиглагдсан тул тайлбар, тодруулга авах ажиллагаа хийгдэж байна. Энэ асуудлыг мөн хөрөнгө оруулалтын завсрын аудитаар эцэслэн шийдвэрлэнэ.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 373 төсөл, арга хэмжээнээс 30 хувь нь огт хэрэгжээгүй байна.

2.2.1. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байхад төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглалтад оруулсан нь төлөвлөсөн зорилт, үр дүнд хүрэх боломжийг хязгаарлаж, зөрчил одоог хүртэл арилаагүй байна.

2.2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 30 хувь нь огт хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй шалтгаан нь магадлалын дүгнэлтгүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн, төсөв батлагдсанаас хойш зураг төсөлд магадлалын дүгнэлт гаргуулсны улмаас батлагдсан төсөвт өртөг багадаж худалдан авах ажиллагаа зохион байгуулах боломжгүй болох, тендерт компани оролцохгүй байх, малын тоо

толгойн татварын орлого бүрэн төвлөрөхгүй байх зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна.

2.2.1.2 Комиссын гишүүдийн үүрэг, даалгавар биелээгүй байхад комисс төсөл, арга хэмжээг хүлээн авснаас зөрчил одоог хүртэл арилаагүй байна. Тухайлбал:

- “Талын наран зохиолч яруу найрагчдын цэцэрлэгт хүрээлэн /Баруун-Урт сум/” төсөл, арга хэмжээний усалгааны системийг шалгаж хүлээлгэж өгөөгүй.
- “Өрхийн эмнэлгийн барилга /Баруун-Урт сум /” төсөл, арга хэмжээний хувьд барилгын дотор тал цас, борооны усанд автах, бохирын худаг хөлдөх, бохир сагаж урсах, агааржуулалтын хоолой онгорхой, өрөөнүүд хүйтэн
- “Уртын голын цэцэрлэгт хүрээлэнгийн хамгаалах зурвасын хашаа барих” төсөл, арга хэмжээний том хаалга дээр лого хийх, том хаалганы дугуйн чанар муу зэрэг асуудлууд гарсан.

Дээрх асуудлуудаас болж эдгээр төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин, үр дүнд хүрч чадахгүй байна.

2.2.1.3 Комиссын гишүүдийн үүрэг биелэгдээгүйгээс төсөл, арга хэмжээний чанар хангагдаагүй зөрчил үргэлжилж байна, үүнийг арилгахын тулд хяналт, хүлээн авах комиссын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 373 төсөл, арга хэмжээнээс 112 буюу 30 хувь нь огт хэрэгжээгүй байна.

2.2.2.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг нийт батлагдсан төсөл арга хэмжээтэй харьцуулж үзэхэд Түмэнцогт, Сүхбаатар сумдын төсөл арга хэмжээ 80-аас дээш хувь нь бүрэн хэрэгжсэн байна. Аймаг болон Мөнххаан, Наран, Халзан, Онгон сумдын хувьд батлагдсан төсөл арга хэмжээний 50-58.7 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт4. Төсөл арга хэмжээний хэрэгжилт

Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй		Нийт төсөл, арга хэмжээ		Хувь
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	
Аймаг	44	13,151,971	18	11,631,388	13	6,026,389	75	34,483,958	58.7
Асгат	18	202,000	3	645,438	5	135,000	26	1,059,438	69.2
Баруун-Урт	30	1,783,554	4	1,389,968	7	2,083,477	41	5,256,998	73.2
Баяндэлгэр	25	316,780		186,500	8	1,130,000	33	1,633,280	75.8
Дарьганга	19	387,153	1	140,245	11	489,499	31	1,016,897	61.3
Мөнххаан	13	416,000	3	321,324	10	651,304	26	1,388,627	50.0
Наран	10	643,991		1,090,343	8	25,000	18	1,759,335	55.6
Онгон	7	311,406	3	95,700	5	1,082,418	15	1,489,523	46.7
Сүхбаатар	17	1,381,071	3	325,590	1	2,844,380	21	4,551,041	81.0
Түвшинширээ	21	338,500		80,000	8	577,500	29	996,000	72.4
Түмэнцогт	16	407,703		224,601	2	199,776	18	832,080	88.9
Уулбаян	17	229,154	4	548,213	2	50,000	23	827,368	73.9

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө									
Халзан	8	222,014	1	0	6	428,723	15	650,737	53.3
Эрдэнэцагаан	35	792,702	3	4,896,340	15	1,405,144	53	7,094,187	66.0
Нийт	196	20,583,999	51	21,575,650	112	17,128,609	373	63,039,467	52.5

Эх сурвалж: Удирдлага мэдээллийн систем

2.2.2.2. Бодлогын баримт бичиг болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний орон нутгийн хөгжилд үзүүлэх хувь нэмэр, үр нөлөөг хэмжихдээ хэрэгжилтийг харгалзан үздэг бөгөөд Сүхбаатар аймгийн ОНХС-аар батлагдсан төсөл, арга хэмжээний бүрэн хэрэгжсэн хувь дунджаар 52.5 хувьтай байгаа нь өмнөх аудитаар 66.0 хувь байсан үзүүлэлтээс 13.5 нэгж хувиар буурсан нь магадлалын дүгнэлтгүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн, зураг төсөл батлагдаагүй, тендерт компани оролцоогүй зэрэг шалтгаанаас үүдэж төсвийн үр ашгийг бууруулж, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулах эрсдэл үүсгэж байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

2.3.1.1. Аймаг, сумын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалтыг авч үзэхэд бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний урсгал зардлаас бусад хөрөнгийн шинж чанартай 196 төсөл арга хэмжээний 11,014.3 сая төгрөгийн үнийн дүнтэй барилга, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

2.3.1.2 “Багийн нутаг дэвсгэрийг камержуулах” төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн аваад аймгийн Цагдаагийн газарт ашиглаж байсан ба 2024 онд Теле камерын хяналтын дэд төвд нүүлгэн шилжүүлэх явцад шилэн кабель тасарснаас одоогоор ашиглалтгүй байна. Теле камерын хяналтын дэд төв нь Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-тай хамтран засварлах ажил хийгдэж байна.

2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна.

2.3.2.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр буй болсон хөрөнгийг холбогдох шийдвэрийг үндэслэн данс бүртгэлд тусгаж байна. Улмаар сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө нь ашиглагч байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хяналтад орж, хадгалалт, хамгаалалтыг тухайн байгууллагууд хариуцаж байна.

БҮЛЭГ В. САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭР ОЛГОЖ, МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН, ҮНЭН ЗӨВ БАЙРШУУЛАН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1. Захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, санхүүжилтийг зөвхөн бодит гүйцэтгэлийн дагуу олгох шаардлагатай байна.

3.1.1. Барилгын ажлын санхүүжилт, материалын чанар, тухайн үеийн зах зээлийн үнийг бодитоор хянахын тулд хяналт шалгалтыг системтэй хэрэгжүүлж, албан хаагчдыг төсөвчний сургалтад хамруулах шаардлагатай байна.

3.1.1.1. Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй 2024 онд танилцаж ажилласан боловч хяналт хийсэн талаар тайлан гаргаагүй байна.

3.1.1.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба сумдын ОНХС-ийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн боловч аймгийн ОНХС-ийн үйл ажиллагаанд 2025 оны 11-р сард хяналт, шалгалт хийх төлөвлөгөөтэй байна. Тус байгууллагын хяналт шалгалт хэрэгжүүлэгч албан хаагч нар төсөвчний анхан шатны сургалтад хамрагдах шаардлагатай байна. Мөн барилгын төсвийн программтай болж барилгын ажлын явцын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгож байгаа эсэхийг хянах, түүнчлэн барилгын ажлын материалын чанарыг төсөвт тусгасан үнэ өртөгтэй дүйж байгаа эсэхийг шалгаж байх шаардлагатай байна.

3.1.2. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага хийгээгүй ажлыг хийснээр гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлэхгүй байна.

3.1.2.1. 2024 онд бүх сумд “Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагч” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж, барилгын техник хяналтыг тус байгууллагаар гүйцэтгүүлж байна.

3.1.2.2. Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагч” ОНӨААТҮГ нь 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт 15,236.8 сая төгрөгийн өртөг бүхий 26 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

3.1.2.3. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага хийгээгүй ажлыг хийснээр гүйцэтгэлийг баталгаажуулсан байна. Тухайлбал: Эрдэнэцагаан сумын “Засмал зам тавих” төсөл, арга хэмжээний хувьд түр замын ажил нь ажлын зураг, нарийвчилсан төсөвт өртөггүй, замын үндсэн трасс дээгүүр хийсэн гэж 86.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн хайрга, дайргыг 5 км-ээс тээвэрлэснээр гүйцэтгэл гаргаж, газар шорооны ажил дутуу хийгдсэн байхад гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилт олгосон.

3.1.2.4. Наран сумын “Шинэ уурын зуух барих” төсөл, арга хэмжээний хувьд хяналтын гэрээтэй боловч хяналт хийгээгүй, илүү санхүүжилт олгосон.

3.1.2.5. Захиалагчийн хяналт хангалтгүй, гүйцэтгэлийг баталгаажуулахдаа хийсэн ажлыг бүрэн шалгаагүй тохиолдолд төсөл, арга хэмжээний санхүүжилтийг үндэслэлгүйгээр олгосноос хөрөнгө оруулалтын үр ашиг буурах эрсдлийг үүсгэх үр дагавартай байна.

3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмж дутуу хэрэгжилттэй байна.

3.1.3.1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн зөвлөмж, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа. Үүнд:

Хүснэгт 5. Зөвлөмжийн хэрэгжилт

Хэнд өгсөн	Зөвлөмж	Зөвлөмжийн хэрэгжилт
Аймаг, сумын ИТХ-д	1. ОНХС-ын хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд ОНХС-ын үйл ажиллагааны журмын 9.4 дэх заалтын дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хорооны хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх.	Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй 2024 онд танилцаж ажилласан боловч хяналт хийсэн талаар тайлан гаргаагүй байна.
Аймаг, сумын Засаг дарга нарт	1. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.3, 3.4-т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн журмын хэрэгжилтийг хангаж ажиллах. 2. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4, 9.5-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах.	Аймаг сумын Засаг дарга нар ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.3, 3.4-т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба сумдын ОНХС-ийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн боловч аймгийн ОНХС-ийн үйл ажиллагаанд 2025 оны 11-р сард хяналт, шалгалт хийх төлөвлөгөөтэй байна. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс аймаг, сумдын ОНХС-ийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Эх сурвалж: ИТХ, Засаг дарга нарын албан бичиг

3.1.3.2. ОНХС-ийн үйл ажиллагаанд тодорхой ахиц байгаа боловч хяналт-шинжилгээ, дотоод аудитын тогтолцоо сул, үр дүнг тайлагнахгүй байгаа нь гол дутагдал болж байна. Иймээс цаашид хяналтын байгууллагууд ажлаа төлөвлөгөөний дагуу хугацаанд нь хийж, гарсан дүнг албан ёсоор тайлагнаж, ил тод байдлыг хангах шаардлагатай.

3.2. Сумдын байршуулж буй мэдээллийг удирдлагын мэдээллийн систем болон шилэн дансанд бүрэн гүйцэд оруулаагүйгээс төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын мэдээлэл бүрэн ил тод бус болж, хяналт, аудитын үр дүн буурах, шийдвэр гаргах үйл явц удаашрах эрсдэл үүсэж байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан байна.

3.2.1.1. Сумдын ЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж, аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн байна.

3.2.1.2. Аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс аймаг, сумын ОНХС-ийн 2024 оны хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна.

3.2.1.3. Тус аудитын хугацаанд иргэдээс авсан санал, асуулгын нэгтгэлээс авч үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлсэн ажлын талаар иргэд олон нийтэд мэдээлэх, тайлагнах ажил хангалтгүй гэж иргэд үзэж байна. Иймд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр мэдээлэл бэлтгэж, иргэдэд олон нийтийн цахим сүлжээгээр ил тод мэдээлэх шаардлагатай байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээний 99.5 хувийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

3.2.2.1. Аймаг, сумын ОНХС-ийн 2024 онд бүрэн хэрэгжсэн 10,178.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон 196 төсөл арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээ данс бүртгэлд тусгаагүй байна. Төсөл арга хэмжээний бүртгэлийг төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө, нийтийн эзэмшлийн үндсэн хөрөнгө, бараа материал, урсгал зардал, бүртгэлд тусгаагүй гэсэн ангиллаар дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 6. Төсөл арга хэмжээний данс бүртгэл

/сая.төг/

№	Үзүүлэлт	Бүрэн хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээ	Төсөвт байгууллагын -Үндсэн хөрөнгөөр	Нийтийн эзэмшлийн -Үндсэн хөрөнгөөр	Бараа материал	Урсгал зардлаар хүлээн зөвшөөрсөн	Бүртгэлд тусгаагүй
1	Төсөл арга хэмжээ	196	92	10	35	58	1
2	Мөнгөн дүн	10,178.3	7,205.4	518.2	914.7	1,512.8	27.1

Эх сурвалж: Аймаг, сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан

3.2.2.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр баригдсан “Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэн”-г данс бүртгэлд тусгаагүй байна. Гүйцэтгэгч компани нэгж өртгийн төсвийг гаргаж ирүүлээгүй тул ОНӨГ-аас бүртгэлд тусгах боломжгүй байгаа талаар АЗДТГ-т мэдэгдсэн боловч одоог хүртэл гүйцэтгэлийн төсвийг нэгж өртгөөр гаргаж ирүүлээгүй байна.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системд олгосон санхүүжилтийн мэдээллийг бүрэн гүйцэд мэдээлсэн байна.

3.2.3.1. Аймаг, сумын ОНХС-ийн санхүүжилтийн мэдээлэл нь төрийн сангийн системээс татагдан бүрэн мэдээлэгдсэн байна.

3.2.3.2. Сумдын ОНХС-ийн төсөл, арга хэмжээнд ЗДТГ-ын холбогдох албан хаагчид сар бүр мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, төсөв, санхүүгийн хяналт, гүйцэтгэлийн үнэн зөв байдлыг ханган ажиллаж байна.

3.2.3.3. Удирдлага мэдээллийн системд төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэгжилтийн явцын фото зураг зэргийг тогтмол оруулж байгаа боловч иргэд энэ сайтын талаар мэдээлэлгүй байна. Иймд тус сайтыг иргэдэд сурталчлах шаардлагатай байна.

3.2.4. Аймгийн ЗДТГ-ын ОНХС-ын мэргэжилтэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэлд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2.4.1. Шилэн дансны цахим системд хөрөнгө болон урсгал зардлаар тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг сар бүр, 7 хоногийн дотор байршуулдаг байх шаардлагатай. Гэтэл 2024 онд tender.gov.mn сайтад тендер зарласан төсөл, арга хэмжээний мэдээллийг шилэн дансны мэдээлэлтэй харьцуулахад Аймаг болон Баяндэлгэр сумын тендерийн ерөнхий мэдээлэл огт байршуулаагүй, харин Онгон, Сүхбаатар, Баруун-Урт сумдын тендерийн ерөнхий мэдээллийг дутуу байршуулсан байгаад зөвлөмж өглөө.

3.2.4.2. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтын талаар шилэн дансны нэгдсэн системийн бусад хэсгийн бонд.... төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт төсөл арга хэмжээний Засаг даргын захирамж шийдвэрийг Эрдэнэцагаан сум дутуу, Баяндэлгэр сум огт оруулаагүй байгаад зөвлөмж өгсөн.

---оОо---

Холбогдох байгууллагын санал:



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Сүхбаатар, Баруун-Урт, 7-р баг, Нутгийн удирдлагын
ордон

Утас: 70518585, Факс: 70518585

Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn

Цахим хуудас: Sukhbaatar.gov.mn

2025.10.02 № 05/1123

танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт зарцуулалт үр нөлөө сэдэвт аудитын тайланд дараас тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1.ОНХС төсөл арга хэмжээний журмын дагуу санал асуулгын хуудас, бүлгийн ярилцлага, цахим хэлбэр болон техник технологийн дэвшилтэт аргыг ашиглан авах боломжтой гэж заасан байдаг. Сумдын хувьд ОНХС-ын төсөл арга хэмжээнд иргэдээс санал асуулга авахдаа цаас болон бүлгийн ярилцлагын аргыг түлхүү хэрэглэж байна. Аймгийн ОНХС хөрөнгөөр ирэх онд хийгдэх төсөл арга хэмжээний санал асуулгыг google платформыг ашиглан олон нийтийн сайтад байршуулан цахим хэлбэрээр авдаг. Энэ нь цаг хугацаа, төсөв хэмнэх давуу талтай байна.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих" журмын 2.7 заалтад Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 30 хүртэл хувийг хоршоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хүртэлх хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаа болон програм хангамжийн зардалд, 10 хүртэлх хувийг аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан байгууллагын саналыг харгалзан сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг урамшуулахад зориулан хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулж болно гэж заасан.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас ирүүлсэн судалгаагаар талх нарийн боов, цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт, гоо сайхан маниюкр, хөдөлмөрт бэлтгэх ур чадварын сургалт, аж ахуй эрхлэлт зэрэг сургалтуудад 270 орчим иргэн хамрагдсан байна.

Мөн 2024 онд аймгийн Засаг даргын тамгын газраас хоршоод, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, малчдын 45 иргэний бүрэлдэхүүнтэй багийг Шилийн гол аймгийн сүү цагаан идээний үйлдвэртэй танилцуулах, шинэ санал санаачилга олж авах зорилгоор туршлага

судлах аялал зохион байгуулсан байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон төслийн газраас жил бүр туршлага судлах, чадавхжуулах сургалт зохион байгуулж байгаатай холбоотой ОНХС -ийн хөрөнгийг иргэдийн саналд тулгуурлан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зарцуулж байна.

3.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний хувьд шилжих хөрөнгө оруулалтаар төсөвт өртөг 710 сая төгрөг, тухайн онд санхүүжих 153,3 сая төгрөг, шинэ хөрөнгө оруулалтад 936 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ирэх онд хэрэгжүүлэх ажлын зураг төсвийг тусган ажилласан. Тоног төхөөрөмжийн өртгийг гадаад дотоодын цахим худалдааны сайтаас судалгаа хийн тухайн тоног төхөөрөмжийг худалдан борлуулдаг 3 хүртэлх компанитай холбогдон үнийн санал авч боловсруулж байна. Тоног төхөөрөмжийн судалгаа мэргэжлийн байгууллагаар хийлэх нь төсвийн хувь өртөг өндөр, сайт болон худалдан борлуулагч компаниудаас санал авах судалгаа нь ижил байдаг.

4.Барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүрмийн 8.6 заалтад Комиссын дарга барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүгнэлт гаргаж, баталгаажуулсан бол ажлын 5 өдөрт багтаан тухайн нутаг дэвсгэрийн аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж, ашиглалтад оруулна. Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг үндэслэн эцсийн санхүүжилтийг олгож байна. Мөн хуулийн 8.2. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

8.2.1. барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт

8.2.2. энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаадагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт гэж заасан байдаг. Иймд хууль дүрэмд нийцүүлэн ажиллаж байгаа ба цаашид улсын комиссын үйл ажиллагаанд хэлтсийн зүгээс хяналт тавьж засаж сайжруулах тал дээр хамтран ажиллахаа илэрхийлж байна.

ОНХС -ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийг шилэн дансанд тогтмол тайлагнаж байна. 2024 оны 5 сард ОНХС хариуцсан мэргэжилтэн шинээр томилогдож өмнө нь үүрэг гүйцэтгэж байсан мэргэжилтнээс ажлын чиг үүрэг салгах явцад худалдан авах үйл ажиллагааг шилэн дансанд мэдээлэх ажил орхигдсон тул ОНХС мэргэжилтэнд хариуцуулахаар шилжүүлсэн болно.



Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
Хэлтсийн дарга
Гомбожав Мөнхзаяа
2025-10-02 15:36:56

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын БОНХҮБТХ-аас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1	АЗДТГ-ын БОНХОБТХ-д өгсөн зөвлөмжийн 1 дэх хэсгийг илүү тодорхой болгож ОНХС-ын үйл ажиллагааны журмын 7.4, 7.5 дахь заалтаар өөрчлөн найрууллаа.
Тайлбар 2	АЗДТГ-ын БОНХОБТХ-д өгсөн зөвлөмжийн 2 дахь хэсгийг илүү тодорхой болгож ОНХС-ын үйл ажиллагааны журмын 4.2.7, 4.2.8 дахь заалтаар өөрчлөн найруулав.
Тайлбар 3	АЗДТГ-ын БОНХОБТХ-д өгсөн зөвлөмжийн 4 дэх хэсэгт тусад нь тодорхой тусгалаа.
Тайлбар 4	Аудитын тайлангийн холбогдох агуулгад өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөсөн боловч 532.6 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг сумдад зөрүүлж хуваарилсан байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдийн нээлттэй хэлэлцүүлгээр төлөвлөж, хөдөлмөр эрхлэлт, ЖДҮ-ийг дэмжих бодлоготой уялдуулан, техникийн тодорхойлолт, зураг төслийг төсөв батлагдахаас өмнө бэлтгэхгүй байгаа нь илрүүлэлтээр тогтоогдсон бөгөөд энэ нь төсвийн үр ашиг, ил тод байдлыг алдагдуулж, хэрэгжилт хойшлогдох, санхүүгийн алдагдал гарах эрсдэлтэй.
- Барилгын ажлын зураг төсөл болон тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг төсөв батлагдахаас өмнө гаргахгүй байгаа зөрчил давтан гарсаар байгаа нь Төсвийн тухай хуулийн шаардлагыг зөрчиж, 7,869.3 сая төгрөгийн өртөгтэй 28 төсөлд нөлөөлж, хэрэгжилтийг саатуулж байна.
- Захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлэхгүй байгаа нь хийгээгүй ажлыг баталгаажуулж, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгоход хүргэж байгаа бөгөөд Эрдэнэцагаан сумын замын төсөл (86.0 сая төгрөг), Наран сумын зуухны төсөл (237.6 сая төгрөг) зэрэгт илэрсэн алдаа нь материалын чанар, үнийн зөрүүг илтгэж байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 373 төсөл, арга хэмжээнээс 112 буюу 30 хувь нь огт хэрэгжээгүй байгаа нь магадлалгүй төлөвлөлт, тендерийн амжилтгүй байдал, орлогын төвлөрөлт хангалтгүй зэргээс үүдэлтэй бөгөөд орон нутгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Комиссын гишүүдийн үүрэг даалгавар хэрэгжээгүй байхад төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглалтад оруулснаар төлөвлөсөн зорилтод түвшин, үр дүнд хүрч чадахгүй байгаа нь "Талын наран цэцэрлэгт хүрээлэн", "Өрхийн

эмнэлэг" зэрэг төсөлд илэрсэн зөрчлөөр батлагдсан бөгөөд хяналтын хариуцлагыг сулруулж байна.

7. Санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгож, мэдээллийг бүрэн, үнэн зөв байршуулахгүй байгаа нь ил тод байдлыг алдагдуулж байгаа бөгөөд Шилэн дансанд тендерийн мэдээлэл дутуу, Удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй мэдээлэл байгаа нь иргэдийн итгэлийг бууруулж байна.
8. Санхүүгийн хяналт, дотоод аудитын хяналт шалгалт хэрэгжүүлэгч албан хаагч нар төсөвчний анхан шатны сургалтад хамрагдах, мөн барилгын төсвийн программтай болж барилгын ажлын явцын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгож байгаа эсэхийг хянах, түүнчлэн барилгын ажлын материалын чанарыг төсөвт тусгасан үнэ өртөгтэй дүйж байгаа эсэхийг шалгаж байх шаардлагатай байна.
9. Ажлын зураг төсөл нь магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй, хяналтын төсвийг байршуулаагүй, ажлын тендерийг барааны тендерээр зарласан зэргээс болж тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болоход голлон нөлөөлж байна.
10. Иргэдийн саналгүй төсөл баталсан (Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Түмэнцогт сум), нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байдал илэрсэн нь төлөвлөлтийн ил тод байдал, иргэдийн оролцоог хангах хууль, журмын шаардлагыг зөрчиж, хөгжлийн тэнцвэргүй байдал бий болгох эрсдэлтэй.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн ИТХ-д:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хөдөлмөр эрхлэлт, ЖДҮ-ийг дэмжих бодлоготой уялдуулан, хоршоог чадавхжуулах, үйлдвэрлэл эрхлэх барилга байгууламж, ажлын байрыг нэмэгдүүлэх, сургалт, тоног төхөөрөмжийн дэмжлэгийг цогцоор нь батлах.

АЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө тус сангийн журмын 7.4, 7.5- д заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулж, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулан иргэдийн оролцоог бодитой хангах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодорхой хэсгийг тус сангийн үйл ажиллагааны журмын 4.2.7, 4.2.8-д заасантай уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлэх
3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахын тулд зураг төсөл, техникийн тодорхойлолтыг төсөв батлагдахаас өмнө боловсруулж, магадлал хийлгэх,
4. Тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг захиалагч өөрөө тодорхойлохдоо нэгдсэн маягт боловсруулж баримтжуулах, эсхүл мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулах

5. Комиссын гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, биелүүлээгүй нөхцөлд төслийг ашиглалтад хүлээн авахгүй байх зарчмыг мөрдөх.
6. Шилэн дансанд мэдээлэл оруулах албан хаагчийг тодорхой болгож, мэдээллийг тогтмол, бүрэн байршуулж хэвших; удирдлагын мэдээллийн системийг иргэдэд сурталчлах.

Сумдын Засаг дарга нарт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодорхой хэсгийг тус сангийн үйл ажиллагааны журмын 4.4.8, 4.4.9-д заасантай уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлэх
2. Төсөв батлагдахаас өмнө зураг төсөл, техникийн тодорхойлолтыг боловсруулах, магадлалын дүгнэлт авах,
3. Тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг захиалагч өөрөө тодорхойлохдоо нэгдсэн маягт боловсруулж баримтжуулах, эсхүл мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулах
4. Комиссын гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлж, үүргээ биелүүлээгүй нөхцөлд төслийг ашиглалтад хүлээн авахгүй байх.
5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө тус сангийн үйл ажиллагааны журмын 5.2.3-д заасан хэлбэрээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.
6. Шилэн дансанд захирамж, тендерийн мэдээллийг бүрэн байршуулж, удирдлагын мэдээллийн системийг иргэдэд сурталчлан таниулах.

Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагч ОНӨААТҮГ-т:

1. Захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, барилгын материалын чанар, тээврийн зардлын гүйцэтгэлийг нарийвчлан хянаж, барилгы ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах.

Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

1. Нэгж болон нийт үнээр ирүүлээгүй тендерийн төсвийг хүлээн зөвшөөрөхгүй байх; ирүүлсэн нэгж үнийг магадлалаар баталгаажсан төсөвтэй тулган шалгаж, нэгж болон нийт төсвийг бүрэн хавсарган, тендерийн шалгуурт ашиглах.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд:

1. Албан хаагчдыг төсөвчний анхан шатны сургалтад хамруулах, мөн барилгын төсвийн программ хангамж ашиглан барилгын ажлын явцын санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан хянах, барилгын ажлын материалын чанар, төсөвт тусгасан үнэ өртөгтэй дүйж буй эсэхийг тогтмол шалгах.

---o0o---